



ХЭНТИЙ АЙМГИЙН  
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/09

Биндэр сум

Ёс зүйн дэд хороог  
шинэчлэн байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.4, 67.5, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ёс зүйн дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хорооны дарга: Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн

Гишүүд: Дэлгэрхаан багийн Засаг дарга

Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргаж, байгууллага дотроо гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг төлөвлөн зохион байгуулж ажиллахыг хорооны бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн А/40 дугаартай тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА  Т.ӨНӨБОЛД

СЖА0001 9073701